ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2025/040/НА-СТА-ТЕЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | **Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч: Я.Самбуунямм**<br>Утас: 51-261665 Цахим хаяг: Sambuunyamya@audit.gov.mn<br>**Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**<br>Утас: 51-261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn<br>**Аудитын менежер: Э.Энхбаатар**<br>Утас: 51-260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn<br>**Ахлах аудитор: Г.Мөнхчимэг**<br>Утас: 51-261628 Цахим хаяг: Munkhchimegg@audit.gov.mn<br>**Аудитор: Ч.Мөнхбулган**<br>Утас: 51-261628 Цахим хаяг: Munkhbulganch@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2025.04.25 № 1611

танай ____________-ны № ____________-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА Э.ОДБАЯР ТАНАА

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Монгол улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй 1,084.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагаа хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Засгийн Газрын 2024 оны 234 дүгээр “Тогтоолд өөрчлөлт оруулах, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” тогтоолоор Хяналт,

үнэлгээний Үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар хамаарахаар тогтоосон байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулиар 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга нь Төсвийн ерөнхийлөн захирагч болсон байна.

**Бусад асуудал**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж хүргүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2025\0425 SNAG-14.Docx

# 2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/мянган төгрөгөөр/*

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **426,308.3** |
| 33 | АВЛАГА | | 76,809.6 |
| 34 | УРЬДЧИЛГАА | | 111,308.3 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | | 238,190.4 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1,752,475.7** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | | 1,752,475.7 |
| 39200 | Биет хөрөнгө | | 1,424,455.8 |
| 39300 | Биет бус хөрөнгө | | 328,019.9 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **2,178,784.0** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **2,178,784.0** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 2,178,784.0 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 2,178,784.0 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **2,178,784.0** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/мянган төгрөгөөр/*

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | **15,472,199.4** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **1,082,640.8** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 1,082,640.8 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **14,389,558.6** |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | | **13,173,958.8** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 13,173,958.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 8,976,557.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 4,417,394.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 542,982.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 185,578.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 158,901.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 392,851.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 689,314.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 1,220,082.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,369,452.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 4,197,401.3 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | **2,298,240.6** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **119,456.6** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | | **2,178,784.0** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */мянган төгрөгөөр/*

| Код | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | | |
| 8 | Зарласан ногдол ашиг | | |
| 9 | Тайлант үеийн үр дүн | | |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | | |
| 18 | Зарласан ногдол ашиг | | |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 2,178,784.0 | 2,178,784.0 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,178,784.0** | **2,178,784.0** |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */мянган төгрөгөөр/*

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | | **14,389,580.6** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **22.0** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 22.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **14,389,558.6** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **13,255,033.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **13,255,033.0** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 9,057,631.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 4,421,062.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 542,982.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 185,578.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 204,530.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 446,356.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 810,097.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 1,220,082.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,226,942.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 4,197,401.3 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | | **1,134,547.6** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | | **1,134,547.6** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **1,134,547.6** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 1,134,547.6 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | | **(1,134,547.6)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | | **-** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **14,506,607,600.00** | **10,304,243,267.00** | **4,202,364,333.00** | **71.0** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **14,506,607,600.00** | **10,304,243,267.00** | **4,202,364,333.00** | **71.0** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **14,255,808,600.00** | **10,192,179,267.00** | **4,063,629,333.00** | **71.5** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **7,870,740,600.00** | **4,421,062,208.51** | **3,449,678,391.49** | **56.2** |
| Үндсэн цалин | 3,984,997,900.00 | 2,706,128,062.55 | 1,278,869,837.45 | 67.9 |
| Нэмэгдэл | 2,891,339,900.00 | 839,095,600.26 | 2,052,244,299.74 | 29.0 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 410,112,000.00 | 441,134,564.51 | (31,022,564.51) | 107.6 |
| Урамшуулал | 584,290,800.00 | 434,703,981.19 | 149,586,818.81 | 74.4 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,013,780,000.00** | **542,982,525.21** | **470,797,474.79** | **53.6** |
| Тэтгэврийн даатгал | 683,790,500.00 | 369,460,827.14 | 314,329,672.86 | 54.0 |
| Тэтгэмжийн даатгал | 80,622,400.00 | 44,319,655.19 | 36,302,744.81 | 55.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 68,398,000.00 | 22,159,828.08 | 46,238,171.92 | 32.4 |
| Ажилгүйдлийн даатгал | 18,724,400.00 | 21,370,357.31 | (2,645,957.31) | 114.1 |
| Эрүүл мэндийн даатгал | 162,244,700.00 | 85,671,857.49 | 76,572,842.51 | 52.8 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **185,578,100.00** | **185,578,100.00** | **-** | **100.0** |
| Гэрэл, цахилгаан | 22,080,000.00 | 22,080,000.00 | - | 100.0 |
| Түлш, халаалт | 41,957,100.00 | 41,957,100.00 | - | 100.0 |
| Цэвэр, бохир ус | 8,153,200.00 | 8,153,200.00 | - | 100.0 |
| Байрны түрээс | 113,387,800.00 | 113,387,800.00 | - | 100.0 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **231,316,100.00** | **208,358,683.27** | **22,957,416.73** | **90.1** |
| Бичиг хэрэг | 59,901,000.00 | 56,783,750.00 | 3,117,250.00 | 94.8 |
| Тээвэр, шатахуун | 34,901,000.00 | 30,968,158.00 | 3,932,842.00 | 88.7 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 46,613,100.00 | 37,220,219.27 | 9,392,880.73 | 79.8 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 89,901,000.00 | 83,386,556.00 | 6,514,444.00 | 92.8 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,553,441,500.00** | **1,529,968,487.01** | **23,473,012.99** | **98.5** |
| Багаж, техник, хэрэгсэл | 818,441,500.00 | 818,441,500.00 | - | 100.0 |
| Тавилга | 335,000,000.00 | 334,914,820.00 | 85,180.00 | 100.0 |
| Урсгал засвар | 400,000,000.00 | 376,612,167.01 | 23,387,832.99 | 94.2 |
| **Томилолт, зочны зардал** | **815,774,000.00** | **810,097,147.00** | **5,676,853.00** | **99.3** |
| Гадаад албан томилолт | 599,762,400.00 | 599,361,142.00 | 401,258.00 | 99.9 |
| Дотоод албан томилолт | 216,011,600.00 | 210,736,005.00 | 5,275,595.00 | 97.6 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,323,248,300.00** | **1,232,666,090.00** | **90,582,210.00** | **93.2** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 986,820,300.00 | 937,410,800.00 | 49,409,500.00 | 95.0 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 6,371,300.00 | - | 6,371,300.00 | - |
| Даатгалын үйлчилгээ | 10,923,000.00 | 666,252.00 | 10,256,748.00 | 6.1 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 958,000.00 | 726,796.00 | 231,204.00 | 75.9 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 174,500.00 | 121,000.00 | 53,500.00 | 69.3 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 316,825,000.00 | 293,741,242.00 | 23,083,758.00 | 92.7 |
| Газрын төлбөр | 1,176,200.00 | - | 1,176,200.00 | - |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,261,930,000.00** | **1,261,466,026.00** | **463,974.00** | **100.0** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бараа үйлчилгээний бусад зардал | 350,000,000.00 | 350,000,000.00 | - | 100.0 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 911,930,000.00 | 911,466,026.00 | 463,974.00 | 99.9 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **250,799,000.00** | **112,064,000.00** | **138,735,000.00** | **44.7** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **250,799,000.00** | **112,064,000.00** | **138,735,000.00** | **44.7** |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 142,500,000.00 | 112,064,000.00 | 30,436,000.00 | 78.6 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 108,299,000.00 | - | 108,299,000.00 | - |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **14,506,607,600.00** | **10,304,243,267.00** | **4,202,364,333.00** | **71.0** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **14,506,607,600.00** | **10,304,221,267.00** | **4,202,386,333.00** | **71.0** |
| Улсын төсвөөс санхүүжих | 14,506,607,600.00 | 10,304,221,267.00 | 4,202,386,333.00 | 71.0 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **-** | **22,000.00** | **(22,000.00)** | **-** |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 22,000.00 | (22,000.00) | - |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **300** | **228** | **72** | **76.0** |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **150** | **114** | **36** | **76.0** |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 145 | 105 | 40 | 72.4 |
| Үйлчлэх ажилтан | 4 | 8 | (4) | 200.0 |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **150** | **114** | **36** | **76.0** |
| Ажлын албаны албан хаагч (АА) | 140 | 106 | 34 | 75.7 |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10 | 8 | 2 | 80.0 |

## 3 АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Монгол улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2024 оны санхүүгийн тайланд 1 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 1,217.2 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс 1,084.3 сая төгрөгөөр хэтэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 3.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн, алдаа зөрчил

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 79.8 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан байна.

Аудитаар нийт 1,217.2 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс, 1,217.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн байна.

### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн, алдаа зөрчил

***Илрүүлэлт:*** ТЕЗ-ийн харьяа байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,217.2 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн, санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар нийт 139.5 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэнд 139.5 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д *"төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх",* 16 дугаар зүйлийн 16.5.6-д *"дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"* гэж заасантай тус тус нийцээгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Дотоод хяналтыг сайжруулж, санхүүгийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйн нэгдсэн зөвлөмжөөр хангаж ажиллах зөвлөмж өгөв.

## 4 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээнд тайлант онд шилэн дансны цахим системд нийт 54 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчилд 1 зөвлөмж хүргүүлжээ.

# 5 АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## 5.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/сая төгрөгөөр/*

| Д/д | Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА НЭГТГЭЛ** | | | | | | | | | | | | | |
| **ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ** | | | | | | | | | | | | | |
| 1 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар | 1 | 79.8 | | | 1 | 79.8 | 1 | 79.8 | | | | |
| **Нийт дүн** | | **1** | **79.8** | | | **1** | **79.8** | **1** | **79.8** | | | | |

## 5.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/сая төгрөгөөр/*

| Д/д | Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс Төлбөрийн акт | | Үүнээс Албан шаардлага | | Үүнээс Зөвлөмж | | Үүнээс Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | Үүнээс Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ** | | | | | | | | | | | | | | |
| **ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ** | | | | | | | | | | | | | | |
| 1 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар | 7 | 1,217.2 | | | 6 | 1,217.2 | 1 | - | | | | | |
| **Нийт дүн** | | **7** | **1,217.2** | | | **6** | **1,217.2** | **1** | **-** | | | | | |

## 5.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/сая төгрөгөөр/*

| Д/д | Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Албан тушаалтны тоо |
| **ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ** | | | | | | | | | | | | |
| **ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ** | | | | | | | | | | | | |
| 1 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар | 1 | - | | | | | 1 | - | | | |
| **Нийт дүн** | | **1** | **-** | | | | | **1** | **-** | | | |
| **ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ** | | | | | | | | | | | | |
| 1 | Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хороо | 1 | - | | | | | 1 | - | | | |
| **Нийт дүн** | | **1** | **-** | | | | | **1** | **-** | | | |
| **Бүгд дүн** | | **2** | **-** | | | | | **2** | **-** | | | |
| **БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ** | | | | | | | | | | | | |
| **ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ** | | | | | | | | | | | | |
| 1 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар | 2 | 139.5 | | | 1 | 139.5 | 1 | - | | | |
| **Бүгд дүн** | | **2** | **139.5** | | | **1** | **139.5** | **1** | **-** | | | |
| **НИЙЦЛИЙН ЗӨРЧЛИЙН ДҮН** | | **4** | **139.5** | | | **1** | **139.5** | **3** | **-** | | | |